



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 11 өдөр

Дугаар A/98

Зуунмод

“Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний
100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 58 дугаар зүйлийн 58.2.1, Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг угтан орон нутагт Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, ахмад дайчдын алдар гавьяаг алдаршуулах, иргэд хүүхэд залуучуудад цэрэг эх оронч хүмүүжил төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын уялдааг нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны 03 дугаар сарын 09-18-ны өдрүүдэд батлагдсан төлөвлөгөөний дагуу ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Улсын онцгой комиссын шийдвэр, Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярыг ард иргэд, хүүхэд залуучуудад сурталчлах зорилгоор батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгууллахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (Т.Төмөрчөдөр)-т даалгасугай.


3. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын арга хэмжээг Улсын онцгой комиссоос өгсөн шийдвэр, ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан ойн арга хэмжээг сум орон нутгийн иргэдэд мэдээлэл дамжуулж сурталчлах, 100 жилийн ойн баярыг тохиолдуулан “Дайчин алдар”-ын булан байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж, хамтран тэмдэглэн өнгөрүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Зэвсэгт хүчний 100 жилийн ойн арга хэмжээг цаг хугацаанд нь төлөвлөн удирдан зохион байгуулж, тайлан, мэдээг Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлэхийг Цэргийн штаб (Дэд хурандаа Т.Төмөрчөдөр)-т үүрэг болгосугай.

5. 100 жилийн ойн баярын арга хэмжээнд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

6. “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын үйл ажиллагаанд шаардагдах 4,140,000 (дөрвөн сая нэг зуун дөчин мянган) төгрөгийг хуваарилагдаагүй зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т шилэн дансанд байршуулахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг) -д тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.МОНХБААТАР